



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: mlsp@mongolnet.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2020.11.05 № 1/3234
танай 2020.10.30-ны № 411Х-09/6003

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА М.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 10 дугаар тайланг Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Нэгдсэн Үндэстний байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хороонд хүргүүлээд байна.

Тус тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 114.2.6 дахь заалтын дагуу хэлэлцүүлэхээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэл болон тайлангийн хамт хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 31 хуудастай.

Хүндэтгэсэн,

А.АРИУНЗАЯА

153201576


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

"ҮИИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 10 дугаар тайлан

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 10 дугаар тайланг хэлэлцэн дэмжээд, тайланг Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хороогоор хэлэлцүүлэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарт даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 10 ДУГААР ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид 1981 онд нэгдэн орсон билээ. Гишүүн орон энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор, түүний дараа дөрвөн жил тутамд болон шаардсан тухай бүр хүргүүлж байх үүрэгтэй байдаг.

Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах конвенцийн хороо 1982 онд Монгол Улсын 1 дүгээр, 1986 онд 2 дугаар, 1999 онд 3-4 дүгээр, 2008 онд 5-7 дугаар, 2016 онд Монгол Улсын ээлжит 8 ба 9 дүгээр нэгтгэсэн илтгэлийг тус тус хэлэлцэж, 2016 оны 3 дугаар сард Монгол Улсын ээлжит 8 ба 9 дүгээр нэгтгэсэн илтгэлийн талаарх Ажиглалтын дүгнэлтийг ирүүлсэн.

Дүгнэлтэд сайшаан дэмжсэн 19, шаардсан 5, нэн даруй авах арга хэмжээ 3, зөвлөсөн 55 арга хэмжээ, 47 зүйлийн зөвлөмж дурдаж, 4 зөвлөмжийн тайланг 2018 онд ирүүлэхийг хүссэн. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд дээрх Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийн талаарх 8,9 дүгээр нэгтгэсэн илтгэл, хэлэлцүүлгээс Монгол Улсад хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг тусган хэрэгжилтийг ханган ажилласан.

Зөвлөмж 1: Гэр бүл, нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагын талаарх ялгаварласан хэвшмэл ойлголт, эцгийн эрхт ёс давамгайлсан хандлагыг арилгахын тулд нийгмийн бүх түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүст чиглэсэн үр дүнтэй, тогтвортой хэрэгжих арга хэмжээ бүхий иж бүрэн стратегийг цаг алдалгүй баталж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 2: 19(a) Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийг батлах явцыг яаравчлах, охид, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс сэргийлэх, асуудлыг шийдвэрлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хүчирхийллийн хохирогчдын хохирлыг барагдуулах, хамгаалах, буруутай этгээдийг яллах, зохих шийтгэл оногдуулах зэрэг авах арга хэмжээг нэн даруй авах.

Зөвлөмж 3: 19(b) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцон хуульчилсан хууль тогтоомжийг хатуу чанд хэрэгжүүлэх, хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй арга ажиллагааны талаар шүүх, прокурор, цагдаа болон бусад хууль сахиулах ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх хөтөлбөр бий болгох.

Зөвлөмж 4: 19 (e) Хүчирхийллийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд эрхээ сэргээх нөхөн сэргээх үйлчилгээ авах зохистой нөхцлийг бүрдүүлэх.

Харин Монгол Улсын ээлжит 10 дугаар тайланг 2020 оны 07 дугаар сард Конвенцийн хорооны 76 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэх, Конвенцийн хороонд хүргүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/361 тушаалаар

байгуулагдсан салбар дундын ажлын хэсгээс конвенцийн 1, 2-т заасны дагуу хүлээсэн үүрэг; Тогтвортой хөгжлийн зорилтууд; Монгол Улсын 8 болон 9 дүгээр тайланд өгсөн ажиглалтын дүгнэлтийн хэрэгжилтийн байдлын талаар тусгайлан тавьсан 24 асуултын дагуу нотолгоонд тулгуурлан тайлагнаж, Конвенцийн хороо руу хүргүүлсэн.

Монгол Улсын ээлжит 10 дугаар тайланд Засгийн газраас эмэгтэйчүүдийн эрх, хамгаалал, хөгжил, ялангуяа нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар, мөн жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавьж ажиллах үндэсний тогтолцоо, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх салбар дундын тогтолцоог бэхжүүлсэн нь үр дүнтэй үйл ажиллагаа болсныг онцлон дурдсан.

Гэсэн хэдий ч жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах, ялангуяа охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, эмэгтэйчүүдийн ажиллах эрх, ажлын байран дээрх эрхийг хангах, ажил амьдралын тэнцвэрийг хангах зэрэг асуудалд илүү анхаарч ажиллах шаардлагатай байгааг мөн тайланд онцоллоо.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ